

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА

**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 14 ДҮГЭЭР ХОРОО, ӨГӨӨМӨР ЗАХЫН АРЫН ГУДАМЖНЫ
ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖЛЫН ГЭРЭЛТҮҮЛГИЙН ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

2019 ОН

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТООЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТООЗ 1.1	<p>Сүүлийн 2017, 2018 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт; /нотариатаар баталгаажуулах/</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр хийж гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, акт, фото зураг/; 2. Ижил төстэй ажлыг сүүлийн 2 жилийн /2017, 2018 он/ аль нэг жилд ядаж нэг удаа санал болгож буй үнийн дүнгийнхээ 50 хувиас багагүй төсөвтэй ажил хийж гүйцэтгэсэн байх 3 Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 2 жилийн /2017, 2018 он/ борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнтэйгээ дүйцэхүйц байна. 4 Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийнхээ 50 хувиас багагүй байна. <ul style="list-style-type: none"> • Үл хөдлөх хөрөнгийн болон бусад хөрөнгийн баталгаажсан гэрчилгээ /Үнэлгээний эрх бүхий байгууллагаар үнэлэгдсэн байх, Үл хөдлөх хөрөнгийн барьцаанд байгаа эсэх талаарх, Эд хөрөнгийн бүртгэлийн газраас гаргасан лавлагаа, барьцаанд тавихыг зөвшөөрсөн албан мэдэгдэл/ • Арилжааны банкны зээлийн тодорхойлолт /Хадгаламж зээлийн хоршоо болон Банк бус санхүүгийн байгууллагын тодорхойлолтыг тооцохгүй/ 5 Улсын бүртгэлийн гэрчилгээг эхээс хуулбарлан нотариатаар баталгаажуулсан байх /тендер зарласан хугацаанаас хойш/ 6 Татварын цахим тайлангийн системээс авсан цахим тодорхойлолт /Татварын өр төлбөргүй байх/ 7 Харилцагч банкнаас өр авлагын талаарх тодорхойлолт /Улсын бүртгэлийн гэрчилгээн дээр бүртгэгдээгүй банкны тодорхойлолтыг хүлээн авахгүй/ 8 Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт, Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн тодорхойлолт 9 Тендерт оролцогч нь хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүй мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу тендерт оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ. 10 Тендерийн баримт бичгийн 5, 6 дугаар бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлэх. 11 Инженер техникийн ажилтнуудын диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбар болон туршлагын талаарх мэдээллийг тендерийн хамт ирүүлэх. 12 Үнийн саналыг маягтын дагуу ирүүлнэ. 13 Ажлын тоо хэмжээний дагуу тооцсон төсөвтэй, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна. Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох программаар гүйцэтгэнэ. Хөнгөлөлт тооцсон тохиолдолд задаргаа болон үндэслэлийг ирүүлнэ. 14 Захиалагч татвар болон харилцагч банкнаас тендерт оролцогчийн

талаар тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлэх.

- 15 Тендерт оролцогчийг төлөөлөн гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг маягтын дагуу нотариатаар баталгаажуулан ирүүлэх.
- 16 Ажлын гүйцэтгэл болон хугацааны талаар нарийвчилсан график ирүүлэх
- 17 Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэд багтаан барилгын ажлыг дуусгаж хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. Баталгаа гаргаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.
- 18 Эхээс хуулбар хувь хийсэн материалууд нь чанарын шаардлага хангахуйц тод гаргацтай харагдахуйц хуулбарласан байх
- 19 Одоо хэрэгжиж байгаа ижил төстэй ажил гүйцэтгэж байгаа бол хэрэгжилтийн талаар захиалагч байгууллагын тодорхойлолтыг ирүүлэх
- 20 Тендерт оролцогч нь боловсруулсан тендерийн иж бүрдэл, баримт бичгийг электрон хэлбэр /Adobe PDF/-т хөрвүүлж цахим хэлбэрээр ирүүлнэ.
- 21 Хуулбар хувь Шаардлагагүй /цахим тендер/
- 22 Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:

Эрчим хүчний яамны ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн

03.2.1-д заасан: Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар 0.4-10 кВ; эсвэл түүнээс дээш, түүнтэй дүйцэхүйц байна. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон гэрээг эх хувиас хуулбарлан нотариатаар баталгаажуулан ирүүлнэ.

Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа тухайн ажлыг хийж гүйцэтгэх хугацаанд хүчин төгөлдөр байх шаардлагатай ба хэрэв тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа ажил гүйцэтгэж дуусахаар төлөвлөсөн хугацаанаас өмнө дуусахаар байвал түүнийг сунгахаар шийдвэрлэсэн эрх бүхий байгууллагын шийдвэрийг тендерийн хамт ирүүлнэ.

Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Шаардлагатай тоног төхөөрөмж, машин механизмуудын жагсаалт түрээсээр болон хөлсөөр ашиглах техник, тоног төхөөрөмжийн гэрчилгээний хуулбар түүнийг нотлох баримт зураг, түрээсийн гэрээний хуулбар хувийг хавсаргах.

Машин механизмын нэр	Тоо хэмжээ
Угсралтын агергат	1
Автокран 3 тн / түүнээс дээш/	1
Үйлчилгээний машин	1

<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендер оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn –д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг (PKI)-ээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. Тендер оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэр /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100MB-с ихгүй, нэг файлын хэмжээ 15MB-с ихгүй байна.</p> <p>Байгууллагын хаяг: <i>Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 13 хороо, Засаг даргын Тамгын газрын байр, Худалдан авах ажиллагааны алба</i> Давхар болон өрөөний дугаар: <i>1 давхар 121 тоот</i> Огноо: <i>2019 оны 05 дугаар сарын 23-ны өдөр</i> Цаг: <i>10 цаг 00 минут</i></p> <p><i>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийг хүлээн авах боломжгүй.</i></p> <p><i>Тендер хүлээн авах хугацаанаас өмнө илгээсэн тендерийн материалыг буцаан авах, засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй</i></p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: <i>Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 13 хороо, Засаг даргын Тамгын газрын байр</i> Давхар болон өрөөний дугаар: <i>1 давхар 121 тоот</i> Огноо: <i>2019 оны 05 дугаар сарын 23-ны өдөр</i> Цаг: <i>10 цаг 20 минут</i></p>
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, Өгөөмөр захын арын гудамжны гэрэлтүүлгийн ажил, БЗДХААА-19/512</i></p>

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Техникийн нөхцөл:

БЗД 14-р хороо Өгөөмөр захын хойд талаар Нарантуул ОУХТ-ийн хойд хаалга хүртэлх гудамжны гэрэтүүлгийг 35/10 кВ-ын Дорнод-1 дэд станцаас ХБ-29-ийн 10кВ-ын Ахмадын хороолол А, Б фидерийн ХТП-3081 дэд өртөөний 0.4кВ талаас кабель шугам татаж шинээр хийгдэх гэрэлтүүлгийг тэжээх.

БЗД 14-р хорооны урдаас Цагаан хуаран хотхон хүртэлх гэрэтүүлгийг 35/10 кВ-ын Дорнод-1 дэд станцын 10кВ-ын ХБ-29-ийн ХТП-2778 дэд өртөөний 0.4кВ талаас кабель шугам татаж шинээр хийгдэх гэрэлтүүлгийн удирдлагын самбарыг тэжээх.

2. Зургийн даалгавар:

2.1 Шинээр угсрах гэрэлтүүлгийг орон сууцны хороололд 9м-ийн 1 толгойтой, төмөр шонтой, 90Вт-аас дээш чадалтай LED STRADA AEE-ST-90W Маягийн болон түүнтэй дүйцэх үзүүлэлттэй LED гэрэлтүүлэгчээр тоноглож дэд станцаас самбарын тэжээлийг АВВБ 3*35+1*25мм.кв, тулгуур хооронд группийн тэжээлийг АВВБ 3*25+16*16мм.кв маягийн хөндлөн огтлолтой кабель шугамаар тэжээнэ.

2.2 Шинээр угсрах гэрэлтүүлгийг гэр хороололд 8м-ийн 1 толгойтой, төмөр шонтой, 70Вт-аас дээш чадалтай LED STRADA AEE-ST-70W Маягийн болон түүнтэй дүйцэх үзүүлэлттэй LED гэрэлтүүлэгчээр тоноглож дэд станцаас самбарын тэжээлийг АВВБ 3*35+1*25мм.кв, самбараас эхний тулгуур хооронд АВВБ 3*25+1*16мм.кв кабель шугамаар тулгуур хооронд группийн тэжээлийг СИП - 2А 3*16+1*25мм.кв маягийн хөндлөн огтлолтой агаарын шугамаар тэжээнэ.

2.3 Гэрэлтүүлгийн самбар: ШУА-ын Информатикийн хүрээлэнд боловсруулсан төвлөрсөн удирдлагын систем бүхий самбар суурилуулна. Гэрэлтүүлгийн удирдлагын самбар бүрт 10А-ийн автомат, DLMS протоколыг дэмждэг 3 фазын баталгаат, бүрэн электрон, 100А-ийн тоолуур суурилуулах.

2.4 Цагаан хуаран хотхон ХТП -2778-ын 0.4 кВ талаас 100А 3 фазын автомат суурилуулан АВВБ 3*35+1*25мм² хөндлөн огтлолтой хүчний кабель татаж шинээр алсын удирдлагатай самбар суурилуулан, самбараас тулгуур хооронд АВВБ 3*25+1*16мм.кв кабель шугам татаж гэрэлтүүлэг угсарч тэжээнэ.

Төгсгөлийн болон 90 градусаас дотогш өнцөг үүсгэн эргэсэн эргэлтийн тулгуурт троссон татлага хийж өгөхөөр төлөвлөсөн. Шинээр угсрах ГГУС-1-ийн тулгуур №5В, өгөөмөр захын ард угсрах тулгуур №8В-д, нийт 2ш давтан газардуулга, 8В, төгсгөлийн тулгуурт троссон татлага 1ш хийж өгнө.

2.5 Өгөөмөр захын арын гудамжны гэрэлтүүлгийг 35/10 кВ-ын Дорнод-1 дэд станцын ХБ-29-ийн 10кВ-ын Ахмадын хороолол А,Б фидерийн ХТП-3081 дэд өртөөний 0.4кВ талаас 2018 оны I ээлжийн угсралтын ажлаар шинээр суурилуулсан ГГУС БЗД -7406 самбарын баруун хойд гаргалгын гэрэлтүүлгийн төгсгөлийн тулгуур №9-өөс үргэлжлүүлэн СИП утас татаж шинээр хийгдэх гэрэлтүүлгийг тэжээх.

2.6 Нолийн шугамыг гэрэлтүүлгийн шонгийн их биенд уян угсаар болгонд холбож нойлтуулга хийнэ.

2.7 Давтан газардуулгыг бетон суурьтай гэрэлтүүлгийн шонгийн суурийн болгонд газарт суурилуулсан гэрэлтүүлгийн шонгийн их биенд 40*4мм полоса туузан төмрийг гагнаж, газарт 0.5м гүнд суурилуулан L=3м урттай 50*50*5мм газардуулгын 3ш электродонд гагнуураар холбоно. ЦБД-ийн БД 43-101-03*/12-ын 1.6.102-т заасны дагуу давтан газардуулга хийгдээгүй шонгууд байгалийн газардуулагч буюу тулгуурын газар доорхи хэсгээр газардуулгын байгууламжийг ашиглана.

3. Гэрэлтүүлгийн шон

3.1 Шонгийн ажиллах цаг уурын нөхцөл:

-орчны температура: -50 C-с +50 C

-Салхины район: I-IV

3.2 Шонгийн төмөр болон бэхэлгээ нь зэврэлтээс хамгаалж 2 удаа будсан байна.

3.3 Шонг зохих зургийн дагуу чанар, үзэмж, хийц хэсгийг онц анхаарч хийх хэрэгтэй. /Ялангуяа гагнаасын хэсгийг/

3.4 Шонгийн хийцийг үйлдвэрт бэлдэж газар дээр угсарч босгохоор тооцов.

3.5 Гэрэлтүүлгийн шонг хуучин гэрэлтүүлгийн сүүлийн тулгуураас цааш нэмж дугаарлана.

3.6 Гэрэлтүүлгийн шугам, тулгуур болон 0.4кВ-ын ЦДАШ-ын СИП утас хоорондын босоо зай тулгуур дээр 0.1 м, алслалт дунд огтлолцохдоо 1м, газрын түвшингээс 5м-ээс багагүй зайд байрлана. Бүрээстэй утастай агаарын шугам нь барилга байгууламжийн дээвэр дээгүүр гарч болох ба хоорондын босоо зай 2.5м-ээс багагүй байна. Барилга байгууламжийн цул хана хүртэл 0.2м тагт тавцан цонх хүртэл 1м байна. Холбооны утастай огтлолцохдоо хоорондын хэвтээ зай 0.5 м, дагуух хэвтээ зай 1м-ээс багагүй байна. 10кВ-ын агаарын шугамтай огтлолцох хэсэгт утас хоорондын босоо зай 2м, хамгийн ойрын тулгуураас агаарын шугам хүртэлх хэвтээ зай 5м, 1кВ-оос доош АШ-тай огтлолцоход утас хоорондын босоо зай 1м, тулгуураас утас хүртэлх хэвтээ зай 2м, СИП утастай зэрэгцэх хэвтээ зай 0.5м, дулааны болон цэвэр бохир усны шугамтай 1м, худаг, худаг сувгийн тагтай 2м, хамгаалах хоолойд сунгасан бол 0.5м хүртэл ойртож болно.

3.7 Цахилгаан байгууламжийн дүрмийн 6.1-р заалтуудад заасан нойлтуулга, гадна гэрэлтүүлгийн норм дүрмийг баримтлан угсралт хийнэ.

3.8 ГГУС-аас болон бусад кабелиар тэжээлийн үүсгүүр авч байгаа хэсэгт гэрэлтүүлгийн тулгуурыг бетон суурин дээр суурилуулах ба кабелийг сууринд цутгасан хоолойд сүвлэн, гэрэлтүүлгийн шонгийн дотуур сүвлэж холболтын хайрцагт холбоно.

3.9 Газарт суулгах шонг газрын түвшнээс доош 1.8м ухаж суурилуулан, доод ёроолд нь L=430мм-ийн N14 швеллер төмрийг чагтлан ганаж L560мм-ийн 50*50*5 булан төмрөөр 4 талаас нь тулж гагнана. Газар шорооны ажлыг швеллерийн уртад тааруулж ухахаар тооцсон болно.

3.10 Кабелиар тэжээгдэх шонг бетон суурин дээр байрлуулах ба 280*280*10мм-ийн лист төмрийг шонгийн ёроолд гагнаж бетон сууринд урьдчилан цутгаж байрлуулсан М 22-ын 4ш резва боолтонд

бэхэлнэ. Бетон сууринд цутгалтын явцад ф 50мм-ийн PVC хоолой суурилуулж кабель шугамыг төмөр шонгийн голоор сүвлэх боломжтой болгоно.

Ажлын тоо хэмжээ

Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
Кабелийн шуудууг 3-р зэргийн хөрсөнд гараар ухах	МЗ	\38,332
Кабелийн шуудууг 2-р зэргийн хөрсөөр эргүүлж булах	МЗ	29,16
Элсэн дэвсгэр эхний кабельд хийх	м	148
АВВБ 3*35+1*25кв.мм хөндлөн огтлолтой кабелийг шуудуунд сунгах /K=1,02/	м	7
АВВБ 3*25+1*16кв.мм хөндлөн огтлолтой кабелийг шуудуунд сунгах /K=1,02/	м	137
АВВБ 3*25+1*16кв.мм хөндлөн огтлолтой кабелийг яндан хоолойд сүвлэж тавих	м	4
АВВБ 3*35+1*25кв.мм хөндлөн огтлолтой кабелийг бүтээцээр үргэлжлүүлэн сунгах /K=1,02/	м	10
АВВБ 3*25+1*16кв.мм хөндлөн огтлолтой кабелийг бүтээцээр үргэлжлүүлэн сунгах /K=1,02/	м	25
0,4 кв-н 4 судастай 35мм ² хүртэл огтлолтой кабельд лент хэрэглэж хуурай үзүүрлэгээ хийх	ш	12
35мм ² хүртэл огтлолтой кабелийн судсанд төгсгөвч шахах	ш	48
Ган хоолой угсрах D-50м	У.м	4

Гэрэлтүүлгийн 0,4 кв-н ЦДАШ угсрах ажил

Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
0,4 кв-н агаарын шунамын бүрээстэй 3х16+1х25мм ² сип утас завсрын тулгуурт татах	км	0,24

Гэрэлтүүлгийн шон угсрах ажил

Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
Гадна талбайн 1 толгойтой төмөр шонтой гэрэлтүүлэгч газарт угсрах	ш	8
Гадна талбайн 1 толгойтой төмөр шонтой гэрэлтүүлэгч бетон сууринд угсрах	ш	5
Тулгуурт баригч суулгах	ш	8
Тулгуурт татагч суулгах	ш	16
Гэрэлтүүлгийн шонд троссон утсаар татлага хийх	1ш	1
Шонгийн суурийн бэхэлгээний төмөр хийц суурилуулах	тн	0,2368
Гэрэлтүүлгийн шонийн бетон суурь цугтах м200	МЗ	0,95
Гэрэлтүүлгийн шонгийн нүх 3-р зэргийн хөрсөнд гараар ухах	МЗ	10,64
Гэрэлтүүлгийн шонгийн нүх 2-р зэргийн хөрсөөр эргүүлж булах	МЗ	10,08
Гэрэлтүүлгийн шонгийн бетон суурийн нүх 3-р зэргийн хөрсөнд гараар ухах	МЗ	1,875

Гэрэлтүүлгийн шонгийн бетон суурийн нүхийг 2-р зэргийн хөрсөнд эргүүлж булах	МЗ	0,915
--	----	-------

Шонгийн давтан газардуулгын угсралтын ажил

Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
Гэрэлтүүлгийн шонд газардуулгын буулт хийх	1 тулгуур	13
50*50*5мм хэмжээтэй булан төмөр газардуулагчыг гар ажиллагаагаар зоох	ш	6
40*4мм газардуулгын туузан шинийг шуудуунд угсрах	м	12
Гэрэлтүүлгийн шонгийн газардуулгын нүх 3-р зэргийн хөрсөнд гараар ухах	МЗ	6,3
Гэрэлтүүлгийн шонгийн газардуулгын нүх 2-р зэргийн хөрсөөр эргүүлж булах	МЗ	5,66

Гэрэлтүүлгийн самбар угсрах ажил

Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
Электрон тоолуур бүхий алсын удирдлагатай самбар IP65 угсрах	ш	1
3 туйлт автоматыг дэд станцын 0,4 Кв-н хуваарилах шүүгээнд угсрах, гүйдэл 100А	ш	1
Удирдлагын самбарын бетон суурь цутгах м200	МЗ	0,23
Самбарын суурийн нүхийг 3-р зэргийн хөрсөнд гараар ухах	МЗ	0,63
Самбарын суурийн нүхийг 2-р зэргийн хөрсөөр эргүүлж булах	МЗ	0,333
50*50*5мм хэмжээтэй булан төмөр газардуулагчыг гар ажиллагаагаар зоох	ш	24
40*4мм газардуулгын туузан шинийг шуудуунд угсрах	м	105
Гэрэлтүүлгийн газардуулгын нүх 3-р зэргийн хөрсөнд гараар ухах	МЗ	33,75
Гэрэлтүүлгийн газардуулгын нүх 2-р зэргийн хөрсөөр эргүүлж булах	МЗ	32,06

Трассын дагуу ачиж буулгах ажил

Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
Дамартай утас, троссыг агаарын шугамын трассын дагуу ачиж буулгах	тонн	0,1706
Шугамын арматурыг агаарын шугамын трассын дагуу ачиж буулгах	тонн	2,699
Төмөр бетон суурь, хавтан, чагт зэрэг бүтээцүүдийг агаарын шугамын трассын дагуу ачиж буулгах	МЗ	1,18

Зам талбай сэтлэж сэргээх

Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
Бетон зам талбай задалж буулгах	МЗ	1,5
15 мм зузаан бетон зам талбай сэргээх	М2	12

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**
ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх** 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
2. **Төслийн менежерийн шийдвэр** 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
3. **Ажил дуусгаахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх** 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгаахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
4. **Аюулгүй байдал** 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
5. **Зааварчилгаа** 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
6. **Маргааныг шийдвэрлэх** 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
7. **Ажлын хөтөлбөр** **Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ**
7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
8. **Зөрчил, гологдол илрүүлэх** 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
9. **Зөрчил,** 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат

**гологдол
арилгах**

хугацаа¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.

**10. Зөрчил,
гологдол
арилгахгүй
байх**

- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

**11. Үе шатны
ажлын
хуваарь**

- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.

**12. Үе шатны
ажлын
хуваарийг
өөрчлөх**

- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.

13. Алданги

- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

14. Ажил дуусгах

- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.

15. Хүлээж авах

- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

16. Эцсийн тооцоо

16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага

17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

18. Гэрээг цуцлах

18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
- (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
- (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
- (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**19. Гэрээг
цуцалсан үед
хийх төлбөр**

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлээс
чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, Өгөөмөр захын арын гудамжны гэрэлтүүлгийн ажил, БЗДХААА-19/512</i>
ГЕН 2.1	Ажил нь <i>Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, Өгөөмөр захын арын гудамжны гэрэлтүүлгийн ажил, БЗДХААА-19/512</i> -аас бүрдэнэ. Ажлын талбай нь <i>Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо</i> -д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.
ГЕН 3.1	Төслийн менежер нь <i>Гэрээ хийгдэх үед томилогдсон этгээд байна.</i>
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр <i>Гэрээнд заагдсан өдөр байна.</i> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>Гэрээнд заагдсан өдөр байна.</i>
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 3 жил байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,05[хувь] байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 0,5 [хувь] байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг 14 хоног-ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг 14 хоног -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ 500,000/таван зуун мянга/ төгрөг байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын 10 [хувь] -иар тооцно.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/
Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр эхэлж, _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]